



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 07 сарын 27 өдөр

Дугаар 6158

Улаанбаатар хот

Ц.Уранчимэгт сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын 2026 оны 03/9799 дүгээр албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цэдэн-Ишийн Уранчимэг нь Арьсны өвчин судлалын үндэсний төвийн Сувилахуйн албаны даргыг томилохдоо Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон тул албан тушаалын цалингийн хэмжээг 1 сараар 30 хувиар бууруулсугай.

2. Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны системд сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг оруулахыг Арьсны өвчин судлалын үндэсний төвийн Хүний нөөцийн албанд даалгасугай.

3. Ц.Уранчимэгт Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хүлээсэн үүргийг хангаж, мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж ажиллахыг үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Загарсүрэн)-т даалгасугай.

САЙД



Э.БАТШУГАР

141261124